

Адольф Харнак

ХУУЧИН ГЭРЭЭНД НЭМЭЛТ БИЧВЭРИЙГ ХАВСАРГАСАН ШИНЭ ГЭРЭЭ ХЭРХЭН ХРИСТИЙН СҮМҮҮДЭД ИРСЭН БАЙХ ВЭ?

Англи хэлнээс хураангуйлан орчуулсан: Р. Ганболд /докторант/
МУИС, Философи, шашин судлалын тэнхим

Зохиогчийн тухай товчхон

Адольф Харнак нь Эстонид төрж өссөн.

Лейпцигийн их сургуульд суралцаж, эрдмийн зэрэг хамгаалсан байна.

1874 оноос Христийн шашны номлолд холбогдох илтгэлүүд тавьж эхэлсэн нь Гностик үзэл болон Ертөнцийн зөгнөл гэх мэт өвөрмөц сэдвүүдээрээ олны анхаарал татаж, 1876 онд түүнийг онцгой гойд профессор хэмээн тодруулсан юм.

Ертөнцийн эзний талаархи номоо анх 1877 онд хэвлүүлсэн бөгөөд мөн 1885 онд Lehrbuch der Dogmengeschichte хэмээх алдарт номоо хэвлүүлсэн байдаг. Энэхүү бүтээлдээ Христийн итгэл үнэмшил, Грекийн гүн ухаан хоёр нь хоорондоо холилдсоноор Христийн шашны талаархи маш олонянзын үзэл баримтлал бий болсон хэмээн үзжээ. Энэ бүтээлийн хураангуй нь 1889 онд Grundriss der Dogmengeschichte гэсэн нэртэйгээр гарч байжээ.

1886 онд Харнак хуучныг баримтлагч сүмийн эрх мэдэлтнүүдийн хүчтэй эсэргүүцлийг сөрөн Берлин дэх Марбургийн их сургуульд уригдан очжээ. 1890 онд тэрээр Шинжлэх ухааны академийн гишүүн болж, Пруссийн сүмийг эсэргүүцэгчдийн хөдөлгөөнд нэгдэн, Христийн сургаалын талаархи

маргаанд татагдан орсон байна. Харнак сахил хүртэгчид нь эсвэл хэт их, эсвэл хэт бага итгэл үнэмшлийг төрүүлж байна гэж үзсэн юм. Тэрээр Христийн номлолын орчин үеийн асуудлын талаархи хамгийн их бүтээл туурвилтай эрдэмтдийн нэг байсан ба түүний үзэл санаа, аргагүйг бүхэл бүтэн Герман орон даяар, мөн гадаадад ч дэлгэрүүлэн хөгжүүлсэн билээ.

Харнак 1905-1921 оны хооронд Берлин дэх Хааны гэр бүлийн номын сангийн ерөнхий захирал хийж байв. Герман дахь либерал үзэлтэй олон олон профессоруудын нэгэн адилаар 1914 онд Дэлхийн 1-р дайнтай нүүр тулж, Германы дайны зорилгыг тодорхойлж өгүүлэл бичиж байв.

1911 онд Kaiser Wilhelm Gesellschaft (KWG)-Герман дахь Олон Улсын Сэхээтнүүдэд зориулсан нийгэмлэгийн анхны ерөнхийлөгч болж, Германы шинжлэх ухааны академийг улс төрөөс тусгаарлах бодлогын үүднээс нийгэмлэгээ удирдаж байв. Берлинд 1929 онд нээгдсэн тус нийгэмлэгийн төв байр “Харнакийн байшин” нэрээр алдаршсан байдаг.

“Шинэ гэрээний үүсэл” зохиолын товч утга:

Энэхүү зохиолд Христийн сүм хэрхэн Хуучин гэрээнд нэмэлтээр орсон хоёр дахь сургаалыг авсан бэ?, яагаад Шинэ

гэрээ Христын шашны эх сурвалжаас гадна бусад номуудыг агуулдаг вэ?, яагаад Евангел болон Апостол номлогчийн гэж хоёр хуваагдсан бэ?, Шинэ гэрээ нь яагаад ганц биш дөрвөн номлолыг агуулж байгаа вэ?, тэдгээр дөрвөн номлол хэзээ үүссэн ба тэдгээрийн баталгаатай эх номууд нь юу вэ?, Шинэ гэрээнд яагаад зөвхөн ертөнцийн зөгнөл л цорын ганц байр суурьтайгаар үлдсэн бэ?, бусад нь яагаад байж болоогүй гэж?, Шинэ гэрээг зориуд зохиож бичсэн үү? гэх мэт асуудлуудын талаар зохиогч өөрийн үзэл санаагаа дэвшүүлжээ.

Шинэ гэрээг бүтээх болсны шалтгааны тухайд Христийн сургаалыг түгээх хамгийн хүндэтгэлтэй үнэн үгс юу болох, Христ болон түүний зөгнөл ба биелэн хэрэгжихийн холбоо, эзэн тэнгэр Израилчуудад ямар амлалт өгсөн, түүнд итгэхийн учир, эртний уламжлалт сүсэг бишрэлийн хамгийн үнэн хүндэт үгс юу болохыг өгүүлсэн бол, энэхүү нөлөө бүхий ном хэрхэн бий болсон тухайд сүнсэн биеэс урам зориг авсан анхны багш нар хэн бэ, ном зохиолыг зөвшөөрдөг эсвэл түдгэлзүүлдэг эрх бүхий хүмүүсийн бүлгэм ямар эрхтэй болох, Христийн буюу Католик бүтээл туурвил нь өөрийгөө баталгаажуулдаг тухай өгүүлжээ.

Мөн яагаад Шинэ гэрээ чухал хэрэгтэй гэж тооцогддог тухайд түүний үзэл санаа хэрхэн бодитоор оршиж буйг тайлбарлажээ. Шинэ гэрээний агуулгын тухайд, энэ нь эртний сүмийн баталгаа болж байдаг гээд, Христтэй эн тэнцүү мэдрэмж бүхий номлоочид гарч ирсэн тухай гэх мэт олон олон асуудлын талаар өгүүлсэн байна.

Зохиолын нэгдүгээр хэсэг. Хуучин гэрээнд нэмэлт бичвэрийг хавсаргасан

Шинэ гэрээ хэрхэн Христийн сүмүүдэд ирсэн байх вэ?

Христийн шашныг номлож эхэлсэн үеэс Христийн сүмүүд Хуучин гэрээг эзэмшиж буйдаа сэтгэл хангалуун байсан нь бичигдсэн баримт гэрчлэлээс тодорхой харагдана. Цаг хугацаа улиран өнгөрөхөд тус бичвэрүүдэд сүм нэмэлт өөр бичвэр оруулсан гэдгийг мэдэж байх хэрэгтэй юм.

Чухамдаа 1-р зууны үед Еврейчүүдийн дунд ч Хуучин гэрээ тэгтлээ хаалттай байгаагүй юм. Үүний 3дахь хэсэг одоог хүртэл зарим талаараа ойлгомжгүй байдаг нь юуны өмнө грекээр ярьдаг еврейчүүдтэй болон Палестиний ариун номын цуглуулга тарж бутарсантай холбоотой.

Яг үнэндээ Хуучин гэрээ оршин тогтноход Шинэ гэрээний үүсэл дохио сануулга болж, хэдэн арван жилийн турш Хуучин гэрээ саад бартааг туулан оршиж байсаар ирсэн нь онцгой. ...Цаг хугацаа шилжин өөрчлөгдөхийн хэрээр Шинэ гэрээ үүсэх өөр боломж гарц үүсч байв. ...Тэдгээр нөхцөл шалтгаануудыг тодорхойлох доорх 3 асуулт байна:

(А) Шинэ гэрээ гарах үндэслэл юу вэ?

(В) Хаанаас ийм бүтээл бүтээх хэрэгцээ шаардлага гарсан бэ?

(С) Шинэ гэрээ нь чухам яагаад шаардлагатай болсон бэ?

(А)...Шинэ бичвэрүүд Хуучин гэрээтэй тал бүрээр төстэй байхыг шаардсан байна.

1. Эртний Христын эхэн үеэс гарч

ирсэн Есүсийн талаарх яриа, түүний сургаалууд нь хамгийн агуу хүч, Эзэн тэнгэрийн хүндлэл байлаа. Есүс ч үүний талаар тайлбарласан байдаг. Түүний өөрийнх нь мессеж бол “би ирлээ”, “би чам руу очиж байна” гэсэн үг байв. Үүгээр Эзэн тэнгэрийн дүрмийг бий болгож, шавь нарыгаа тууштай бат итгүүлж, өөрийгөө бүрэн таниулсан юм. Ингээд Хуучин гэрээнд Эзэн гэсэн үг байнга дурдагддаг ба Хуучин гэрээнд бичигдээгүй хоёр дахь бичвэр нь илүү анхаарал татаж, Шинэ гэрээний цөм нь болж өгсөн юм...

2. Хоёр дахь учир шалтгаан нь St Paul (Гэгээн Паул)-д үхээд сэхэхийн онцгой хүчийг үзүүлсэн нь Эзэн тэнгэрийн сүр хүчийг, мөн Есүсийн амьдралын шийдвэрлэх мөчийг харуулахыг зорьсон юм. Үүний нөлөөн дор Эзэн тэнгэрийн сургаалыг Сайн мэдээ хэмээн номлогчдоор зарлуулж, ...Христчүүд өөрсдийн сүсэг бишрэлийн баталгаагаа харуулж, үл итгэгч Еврейчүүдийн бодлыг няцаах гэж, Библийн зөгнөл хэрэгжсэн талаар батлах гэж тэд маш их хүчин чармайлт гаргасан гэж дуулсан юм байна.

Ийм учраас Христийн сүмд Хуучин гэрээнээс илүү Есүстэй холбоотой ...үйл явдал маш их хэрэгтэй байв. Мөн зөгнөл болон түүний биелэлтийг хооронд нь нарийн нягталсан харьцуулалт зайлшгүй шаардлагатай байв. ...Хоёр дахь шалтгааны нөлөөгөөр эхнийхэд гарч эхэлсэн “Ариун Библи ба эзэн” гэсэн ухагдахуун нь “Ариун Библи ба Эзэн тэнгэрийн сургаал” хэмээн өөрчөгджээ. Сүмийн түүхэн цаг үеийн байдал нь энэ шинэ нэр ухагдахуунтай таарч, энэ нь Шинэ гэрээний үүсэл болж байв.

3. Гурав дахь үндэслэл нь Гэгээн Паул болон түүнээс суралцсан хүмүүст хамаарна. Үүнийг илэрхийлэх “Христ бол шүүлтийн төгсгөл”, “Моисегийн өгсөн шүүлт”, “аврал ба үнэн нь Есүс Христээр дамжуулан ирсэн юм” гэх мэт үгүүдийг эндээс олж болно.

Паулын Христэд итгэгчид, мөн бусад олон хүмүүс Христийн өөртэйгээ хамт авчирсан тэр зүйлийг Хуучин гэрээтэй холбоотой үгүйг үл харгалзан ямар нэгэн шинэзүйл, Шинэ гэрээгэж томьёолонитгэж байсан юм. “Шинэ гэрээ”-ний үзэл санаа нь гарцаагүй ямар нэг баримт байгаагийн үндсэн дээр бичигдсэн. Гэтэл Гэгээн Паул болон бусад нь тэнд шинэ баримтыг шаардахгүй байгааг бид анзаарсан юм. Яагаад болохгүй гэж? Яагаад гэвэл ердөө л зөгнөлийн талаархи эшлэлүүдийг Хуучин гэрээнээс авсан гэж бодож байна. Тэд өөрсдөө эртний Библи танилцаж, чухамхүү тэр шинэ гэж яригдаад байгаа Хууль болон Ертөнцийн эзний сургаал хоёрын хоорондын ялгааг Шинэ гэрээнээс олсноор түүний авралын дохиог Еврей бус хүмүүс аль хэдийн мэдсэн гэдгийг нь ойлгуулсан юм.

Гэвч яг энд л тодорхойгүй юм харагдаж байна. Хэдий Гэгээн Паул үүнд нөлөөлсөн ч, Эзний хууль болон номлогчдын хооронд хил хязгаар нь хаана байна вэ гэсэн асуулт үүснэ. Энэ нь Хуучин гэрээн дэх бүх зүйл шинэ бөгөөд тэнд гагцхүү зөв ойлголтыг шинээр газар сайгүй тарааж байгааг шалгах шаардлага л байгаа гэсэн үг үү? Эсвэл Хуучин гэрээн дэх бүхэн чухамдаа шинэ гэсэн үг үү? Гэвч Эзэн тэнгэр энэ бүгдийг бидэнд сургах зорилгоор “хуучин” гэдэг нэрийн доор

нуусан байна.

Ийм байх нь Еврейчүүдтэй холбоотой маргаан, сүмийн амьдрал болоод тэдгээрийг захирдаг сэхээтэн язгууртнуудад цочрол өгөх хүнд асуудал болоод байсан нь өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж буй Христчүүдэд мэдрэгдэж эхэлсэн юм. Энэ бэрхшээлээс яаж гарсан юм бэ? Тэдэнд нөлөөлөхүйц баримт хэрэг болов...Харин хаанаас ийм баримт бичиг олсон юм бол?

Хэн ч Жастин болон Тайфогийн харилцан ярилцахыг яг тэр бичээч Шинэ гэрээн дээр хамгийн ихээр сэтгэл нь хөдөлж уйлж бичсэн шиг уншиж байгаагүй байх. Үүнээс харахад тэр энэ бүхнийг шууд бичих ямар ч боломжгүй бөгөөд тэр энэ бүгдийг эцэж шантаршгүй бичихээр сонгогдсон хүн юм.

Дөрөв дэх хамгийн сүүлийн шалтгаан нь, 2-р зуунаас хойш Христийн сүмд нэлээд чухлаар тавигдаад байсан асуудлаас үүсчээ. Боломжийн гэж юу болох, боломжийн биш зүйл гэж юу болох вэ? Уламжлалт үзэл санаатай юу таарах вэ? Үүнтэй юу зөрчилдөж байна вэ? Католик гэж юу гэсэн үг вэ? Эдгээр асуултууд юунд итгэж болох, мөн юу сайн гэдгийг хянан нягталж шийдвэрээ хийхэд нөлөөлөх ноцтой асуултууд байлаа. ...Түүнээс гадна сонголт хийх үйл явц нь Католик гэсэн дан ганц шүүлтээр ч биш, өөрөөр хэлбэл Эзэн тэнгэрийн номлолын шалгуураар чиглүүлэгддэг байна.

Дөрөв дэх шалтгааныг судлаад үзэхэд, Католик болон Эзэн тэнгэрийн сургаал нь Шинэ гэрээний үндэс суурьт нөлөө бүхий баримтууд болж гурав дахь шалтгаантай

холбогдож байгаа юм.

Бид Шинэ гэрээний үүсэл хөгжлийг нь дээрхи шалтгаануудаар жагсаан түүний түүхийг ноороглож үзлээ. Энэ түүх нь нэг талдаа Эзэн тэнгэрийн сургаал номлол, нөгөө талдаа Шинэ гэрээний үндсэн баримтыг шаардаж байгаа юм. Үүнээс гадна мөн энэ нь Католик бичвэрүүдийг баячуудаас хол байлгахыг шаардаж, Христчүүдэд онцгой нэр төрийг хайрлахыг зорьж байв. ...Ийнхүү Шинэ гэрээний түүхэн үүсэл хөгжлийг шалтгаануудаар нь тайлбарлалаа.

(В). Гэвч энэ бүтээлд хаанаас ийм чухал үндэслэл гарч ирэв? Үүний талаар хэлэлцэх гурван зорилго байна.

Нэгдүгээрт, хэдийгээр бүх Христ итгэгчид сүнслэг мөн чанартай боловч тодорхой хэдэн гишүүд нь онцгой нэгэн сүнс атгагчид хэмээн хүндлэгдэж байв.

Христийн сүмүүд 2-р зуунаас эхлэн эдгээр сүнс атгагчдыг өөрийн эрхшээлдээ байлгах болсон юм.

Хоёрдугаарт, Христүүдийн цуглаан дээр Есүс Христийн нэрээр хамтдаа уулзаж, чиглэл авч, эсвэл шийдвэр гаргаж, энэ нь Ариун сүнс байсныг, эсвэл өөрөөр хэлбэл, Эзэн Есүс биднийг чиглүүлэн дэмжигч байсныг таньж мэдсэн билээ.

Гаргалгаа нь: “Ариун Сүнснийг бид сонгосон юм”, эсвэл “Ариун сүнсний хэлсэн зүйл биднээр дамжуулагдсан”, эсвэл “Бид Ариун сүнсний хэлсэн бичсэний дагуу ярьдаг” нь тогтмол ашиглагдаж байна. Гэвч сүм бол өөрөө Ариун Сүнснүүдийн цугладаг онцгой байгууллага мөн. Ямар бичвэрүүд хүлээн зөвшөөрөгдөж, ямар нь болохгүй вэ,

олон нийтэд аль нь уншигдаж, аль нь зөвшөөрөгдөх вэ гэх мэт хандлага руу чиглэсэн хүч ихэссэн байна.

(С). Бидний авч үзээгүй гурав дах асуулт бол: Шинэ гэрээний санаа таамаглал уу, яаж өдий хүртэл оршин тогтнож байна? ... Бид Шинэ гэрээний маш онцгой чухал санааг ухаарснаар гэрэлтдэг. Дээр дурдсанаар, энэ нь үнэн байсан, учир нь олны шүтдэг Христийн бичээсүүд нь үнэндээ Хуучин гэрээг баяжуулсан байв.

Иймэрхүү бичвэрүүд нь худал хуурмаг болон буруу зүйлсийн эсрэг хөрвүүлэгдсэн байх ёстой. Христийн бичвэрүүдийн хамгийн чухал үнэ цэнэтэй баримт нь хуулбар болон эрс тэс байдлыг өдөөн хатгасан итгэгчийн болон Гностик үзлийн жишээ мөн. Нийтийн бичвэр нь маш дэлгэрэнгүй байсан ба Шинэ гэрээний үүслийг тэд ухаарч ойлгож чадсан талаар бичигчид бодит үйл явдлыг яаж бүтээн бичсэн, санаагаа яаж гаргаж ирсэн нь сонирхолтой байв.

Энгийн бичвэрүүдийн “цуглуулга” төгс бүрэн биш байж болох ба их ч бай, бага ч бай зориуд нээлттэй орхисон байж ч болох, ялангуяа төгсгөл нь (жишээ нь нийтийн уншвар) одоо үетэй холбоотой байж баяжуулагдахаар байсан байж ч болох юм. Мөн үндсэн баримтуудын цуглуулга нь аль хэдийн бараг дуусах хандлагатай байгаа бөгөөд мэдээж гэрээний үндсэн баримтуудын цуглуулга нь өөрөө ерөнхий төгсгөл юм.

Зуугаад жилийн өмнө философич Новалис ухаалаг асуулт дэвшүүлсэн байна: Хэн Библийг /Шинэ гэрээний ёс жаягуудыг/ хаагдсан гэж зарласан бэ?

Бидний асуултанд өгөх хариулт бол: Шинэ номнууд нь Эзэн тэнгэрийн Есүс Христээр дамжуулан бий болгосон хоёр дахь гэрээний үндсэн баримтууд байсан гэсэн хатуу чанд мөрдсөн санаа нь “хаалттай” шинэ оюунлаг зэвсгийн анхдагч байлаа. Хэзээ Шинэ гэрээний санаа баттай ойлгомжтой болов? Одоо хэн ч номлогч Паул /vide supra/ -аас илүү туршлага болон түүхэн байр суурьгүй байна. Ер нь тэр хэзээ ч гэрээний “номнууд”-ын талаар бодож байгаагүй, мөн тэр хар модны дараа орох цаг үеэс сонгодог гэрээний цаг үеийг ялгах ааргүй байв. Яаж ч юм аажмаар шинэ “номнууд” гарч ирсэн, мөн аажмаар цаг хугацаа өнгөрөх тусам Христэд харьяалагдах бүх зүйл сонгодог гэх Христийн үеийн санаа өөрөө илүү хүчтэй эргэлзээ үүсгэж байв. Энэ нь дараагийн үеүдэд хүрч чадахааргүй болж, бүхний итгэлийг хүлээсэн загварыг төгс бүтээжээ.

Дараа нь Монтанизмын хөдөлгөөн онцлог байдлаар бий болж, дарангуйлагч энергээр бүхнийг хүчилж, даруу зангаар өөрийгөө халхалсан хуурамч дүр Христ шашинтны эсрэг тэмцэж байв. Өнгөрсөн үед хамгийн өндөр тогтоосон зүйл гэвэл, тэр нь одоогийн зорилго болж өвлүүлсэн хөрөнгөнөөс тэс хол зүйл бөгөөд, Монтанизмын тунхагласан илчлэл болон номлол нь анх хамгаалагчдад ирсэн байдаг ба халдашгүй ариун үүрэг бүхий сүмийн бүрэн бус гэрээ Христийн үед өгөгдсөн, гэхдээ шинэ үзэл /Novum/ болон шинэ үзэлтнүүд /Novissimum/ өсөх тусам өөрийнхөө зөгнөлийг дэлгэрүүлсэн нь анхааруулах бошго болж байв.

Иймд энэ эрин үед хамаарагдахгүй үйл хэрэг бүхнийг үгүйсгэн татгалзах

боломжтой болсон юм. Үнэндээ энэ журмаар Новумийн гэрээ /Шинэ гэрээний номны цуглуулга/ анх баттай бий болжээ. Тэмүүллийн эрин үе өндөрлөлөө, үүнд одоо цаг ч хамаарагдана, Тэртулианы үгсийг ашиглаж байсан сүнснүүд нь яг үнэндээ тэр үед няцаагдаж байсан ном руу цөлөгдсөн юм. Байгалийн цагаар энэ нь одоог хүртэл ялан дийлэх гэсэн дэндүү их хандлага болон түүний хувилбарууд байсаар байгаа тийм маш урт хугацааны өмнөх, бүгдийг хатуу төгсгөлд авчирсан үе бөгөөд Монтанизмын зөрөлдөөн дууссанаас хойшхи бүх үр дүнг харахад, Шинэ гэрээний санаа цугларч бүрэн дууссан байв.

Энэ холбоонд барагцаагаар манай эриний өмнөх 180-170 онд Сардисийн хамба Мэлитогийн, мөн Бага Азийн орнуудын болон Монтанизмын өрсөлдөгч нутгийн уугуулуудын ашиглаж байсан “Хуучин гэрээний номнууд” анх олдсон нь санаандгүй тохиолдол биш байлаа. Мэлитогийн “Шинэ гэрээны ном”-ны мэдлэг нь ганц Бага Азийн орнуудад байгаа юм биш. Euseb –Монтанизмын эсрэг нэгэн нэргүй сурвалжид /барагцаагаар манай эриний өмнөх 192—193 онд/ бичсэн нь: *dedios kai exeulaboumenos me te doxo tisin episungraphein e epidiatassesthai to tes tou euangeliou kaines diathekes loho ho mete prostheinai mete aphelein dunaton to kata to euangelion auto politeuesthai proeremeno.*

Үүнтэй адил өөр нэгэн чухал зүйл бол Тэртулиан руу чиглэсэн баримтууд билээ. Энэ зохиолч нь Католик шашинтан мөн бөгөөд тэрс үзэлт өрсөлдөгч Монтанист болж үргэлж өөртэйгөө зөрчилддөг байжээ. Нэг талаар, тэр хүйтэн цуст бичвэрт

Novum гэрээ, эсвэл Libri nova гэрээний илэрхийллийг ашигласан байж болох юм. Нөгөөтэйгөөр түүнийг буруутгах зүйл нь Шинэ гэрээг бичиж дууссан хэмээн тунхагласан явдал юм. Энэ бүх бичвэрээс үзэхэд, Гностик хямрал нь үнэндээ Христийн болон Католик сүмийг нээх санааг үүсгэснийг харуулсан ба ирээдүйн Шинэ гэрээний бүх материалыг багтаасан цуглуулгыг авчирсан нь Гностикийн уналт биш, харин ч хаагдсан цуглуулбаруудын ойлголтыг шинээр бүтээсэн, мөн Шинэ гэрээний санааг авчирсан Монтанист явдал байсан ажээ.

Мураторийн хэсэгт Шинэ гэрээний бичвэрт хэзээ ч хүлээн зөвшөөрөхгүй сүмийн шийдвэрийг баталж харуулсан юм. Хэдийгээр тус хэсгийн бичээч зориудаар Христийн бичвэрийн цуглуулгыг нээлттэй орхисон ч түүний хувьд одоо хэр нь санаандгүй харж болох Христийн Хуучин гэрээний зөгнөлт бичвэрийг л зөвхөн хүлээн зөвшөөрч болно гэж үзэж байв.

Ийнхүү хоёр дахь гэрээ анх бий болжээ. Анхандаа Авралын Эзэн тэнгэр нь бүтээгч Эзэн тэнгэр хэмээн мэдрэгдсэн учраас түүнийг хадгалсан байв. Яагаад гэвэл, Гэгээн Паулын үзлээр, Христийн шашинтнууд Есүс Христийн гэрээнд туссан түүхэн үзэл санааг маш хурдтайгаар зохион байгуулж хэрэгжүүлсэн нь зөвхөн зөгнөлт бошго нь ч бус, гэрээ өөрөө илүү ач холбогдолтой байсантай холбоотой.

Хуучин гэрээ Шинэ гэрээтэй эн тэнцүү чухал ач холбогдолтойгоор оршин байгаа нөхцөлд үүний хүчин дор оршин байж цааш үргэлжлэх боломжтой. Хоёр гэрээний хооронд холбож өгч буй анхны шашны зохиол нь энэхүү Иранусын

шашны бүтээлээс тод харагдана. Мөн хэдийгээр Иранус хоёр дахь хаалттай гэрээний цуглуулбаруудын талаар мэдээгүй ч, тэрээр Шинэ гэрээнд энэ нэрийг нь өгөөгүй байсан нь одоо хүртэл түүний тайлбар бичээст дурдсанаар, түүнд зөвхөн нэр хэрэгтэй байсан, иймээс л үүнийг хаалттай чигээр нь үргэлжлүүлсэн. Шинэ цуглуулгын номнууд нь нэг талаараа Шинэ гэрээний баримтууд байсан ба нөгөө талаараа Христийн болон Католик шашны сүмийн номнууд юм. Түүнтэй адил загварын номнууд байсан ч энэ бол сүүлчийн хувилбар. Шинэ гэрээ одоог хүртэл хүчтэй нөлөө бүхий байгааг эдгээр таамаглалууд харуулж байгаа юм.

4. Манай эриний өмнөх 200-аад оны үед Тэртулианчууд Хуучин гэрээнд Эночийг нэмэх хүсэлтэй байсан нь тодорхой ба шалтгаан нь түүний хэлсэн бүхэн сургамжтай байдагт оршино.

5. Гэгээн Паул өөрөө Христийн шашинд чухал ач холбогдол бүхий маш баялаг цуглуулгыг санал болгосон байна.

6. (Шашны ном ба Эзэн) “Messiah” гэдэг нь энгийнээр эзэн гэсэн агуулгатай. Христийн болон Хожуу Христийн эрин үед “Шашны ном ба Эзэн”-ий номлол нь шууд ба шууд бус олон янзын гэрчлэлтэй байсан.

7. “Шашны ном ба номлол”

8. Хоёр номлолын аль нь арай эртнийх гэдгийг хэлэлцэхэд цагийн гарз болно. “Evangelium” – Эвангелизм болон энэ үзэл санааны хамгийн эртний түүхийг би өөрийн ном болох “Entstehung und Entwicklung der kirchenverfassung”-д дурдсан.

9. Шинэ гэрээний түүхэнд чухам юуг болсон гэж үзэх, юу болсон байж болох гэсэн үзлийг дэс дараалалтайгаар олж авах хэрэгтэй. Хэрвээ энд буй шалтгаан нь чөлөөт замналаар дүрслэгдвэл бид Есүсийн туурвисан цэцэн үгсийн цуглуулгыг хүлээж байх хэрэгтэй ба зарим элементүүдээр нэмж сайжруулсан нь Хуучин гэрээний хамт байх хэрэгтэй. Цаг хугацааны хувьд үүнтэй илүү холбогдсон нөхцөл байдалд хоёуланд нь яг юу тохиолдсон юм бэ?

Номлолуудын ард цуурхал оршдог ба “The two ways” нь Христийн хувилбартай илүү холбоотой оршдог. “Didache”-д хүлээж авсан сүүлийн бүтээл нь онц сонирхолтой учир нь үүнийг түгээх оролдлого нь зөвхөн ёс суртахуунд биш юм. Христийн бүлгүүдийн хамгийн чухал дэг жаяг (baptism, prayer, fasting, амьдралын дүрэм гэх мэт)-д Есүсийн цэцэн үгсийг түгээх байв, иймээс бүх Христийн бүлгүүд Хуучин гэрээнд бичигдсэн ганц баталгаанд хамаарагдахгүй.

Сүүлд энэ эртний Дидачид “Teaching of the lord” – “Эзний талаарх номлол”, “Teaching of the Apostles” - “Номлогчийн талаарх номлол” хоёул байх хэрэгтэй болсон бөгөөд Христ болон Номлогчийн төстэй тодорхойлолт нь бидний харж байгаагаар Шинэ гэрээний үүслийн гол нөхцөл байсан. Хэтрүүлэггүйгээр, магадгүй хуучны сургаал буюу Q (эртний нэршлээр) Шинэ гэрээний зорилт байсан байх гэж бид хэлж болох юм. Христийн шашин үүнийг Шинэ гэрээ гэж танилцуулах нь хязгаараас давсан зүйл биш байсан юм. Шинэ гэрээ бүтээгдсэний дараа Эзэн тэнгэрийн сургаалын энэ ажил

эзэн болон номлогч нараар тав болон зургадугаар зуун хүртэл үргэлжилсэн.

10. Христ одоо хүндлэгдэж биширмээр, багшаас илүү үйл бүтээж байна.

11. Markan Gospel-н төлөвлөгөө хамгийн ухаалаг нь байж ахлагчийн гол нөлөөллийг үхэл ба дахин сэргэлтийн түүхэнд харуулсан. Хэрвээ Христийн номлолыг домогтой нэгтгэсэн бол энэ нь нэг төрлийн зөгнөсөн түүхийг бидэнд хэлж өгөх байсан. Энэ бол Гэгээн Маркийн өгсөн зүйл. Гэхдээ түүний өгсөн зүйл гэвэл багахан хэмжээний зөгнөл байлаа учир нь гар дээр ирсэн материал нь маш өчүүхэн байсан юм.

12. Түүнчлэн номлолууд “Эзний Библи” хэмээн нэрлэгдэж байсан.

13. Хэрэв өмнө дурьдагдсан шалтгаанууд анхныхтайгаа хамт хөндлөнгийн оролцоогүйгээр чөлөөтэй байсан бол үр дагаварууд нь ийнхүү байх байсан:

Нэг бол бичигдсэн номлол (бидний номлолуудтай адил) Хуучин гэрээнд заасан бүх цол хэргэм болон агуулгатай нь хамт байрыг эзлэх, эсвэл Хуучин гэрээн дэх зөгнөлүүдийн болон Есүсийн түүхийн үйл явдлуудтай эв эетэй байрыг бичвэрт эзлэх байсан (Q болон Дидахетэй адил бүтээлүүдийн цуг). Еврей-Христийн сүмүүдийн оршин тогтнох хугацаандаа “Жүдүүдийн номлол” эсвэл “Эбионитуудын номлол” гэх ганцхан номлолыг Хуучин гэрээнд оруулжээ.

Мөн Египетийн сүмүүд түүхэндээ Хуучин гэрээн дээр нэмж өөр ганцхан шашны номлолтой байсан нь ойлгомжтой.

Үүнээс гадна, маш олон чухал сүмүүд хагас зуун жил зөвхөн нэг номлолыг (магадгүй хэд хэдийг-үүнийг одоогоор хэлэлцэхгүй) Хуучин гэрээний хажуугаар зааж байсан нь лавтай, мөн энэ явдал нь Сири болон Арабын сүмүүдэд III зууны дунд үе хүртэл үргэлжилсэн. Бид энд зөвхөн эдгээр баримтуудыг батлахад анхаарна. Эдгээр номлолууд нь агуулгынхаа хувьд үнэлэгдэж байсан уу, эсвэл бичсэн зохиолч нь чухал хүн байсан эсэх, мөн Хуучин гэрээтэй холбоотой чухал юу байсан бэ? эдгээр нь бидний хэм хэмжээнээс хэтэрсэн асуудлууд юм.

...Юу ч болсон, энэ нь боломжгүй зүйл биш гэдэг нь тодорхой юм. Гэвч одооноос илүү ямар ч нөхцөл байдалд Шинэ гэрээ бичигдсээр байх хэрэгтэйг сануулсан юм. Хэрэв тэр Сайн мэдээнд итгэсэн, эсвэл Сайн мэдээг Шинэ гэрээ гэж итгэсэн бол сүмийн түүхийн явц тийм ч энгийн байгаагүй эсэхийг асуух боломжтой. Хэрэв тэр Паулины захидлуудыг хуваалцах үүрэг хүлээсэн бол сүмийн хувьд Хуучин гэрээ хэтэрхий хүчтэй байх биш үү? Асуулт асууна гэдэг нь үүнд нааштайгаар хариулахыг хэлнэ.

Иоханы Сайн мэдээ гэгээн болгон тодруулсан Паулын одоо ч Гэгээн Марк Гэгээн Льюк байгаа сүмүүдийн төлөө хийсэн зайлшгүй шаардлагатай үйлчилгээг хийж чадахгүй байсан. Бидний Сайн мэдээ болон Паулины захидлуудын оронд ирсэн хоёр дахь боломж нь бид зөн болон биелэл хоёрын холбооны нэгтгэлийг хүлээн авсан байх ёстой. Энэ чиглэлд ямар ч оролдлого байхгүй. Тэр нэгтгэл нь бусад ажлууд (Эзэн тэнгэрийн сургаалыг дагагчдын үйлээс хойшхи)-тай

харьцуулсан Жастины ажлын үр дүнд гарч ирсэн. Мелитогийн Эклогийн тусгай тэмдэглэл (Иосеб). Харамсалтай нь бидний үеэс өмнө алдагдсан бөгөөд энэ нь хууль, аврагчдыг оруулаад эш үзүүлэгчид мөн бидний бүх итгэл үнэмшлийг багтаасан байсан юм.

Христэд итгэгчидийм холбоонд сэтгэл хангалуун үлдсэн байх ёстой гэсэн жижиг асуудал байхгүй байсан бөгөөд тэдгээр шохойн чулуун дээрх тэр хөгжил нь зай багатай, гүн үндэслэлгүй Шинэ гэрээний үр дүн байсан. Азаар аль нь ч энэ үзэл баримтлалд таарах аятайхан хэлбэрийг олоход хангалттай байгаагүй юм. Тиймээс энэ нь сүмд үргэлж л тодорхойгүй байна. Мөн одоогоор Шинэ гэрээний баримтанд ямар ч өрсөлдөгчгүй таарсан нь Дидачийн бичээсүүдэд илэрхий байгааг харж болно.

(14) (Миний хувьд, миний баримт бичиг бол Есүс Христ-асуултгүй бичиг баримт, Түүний загалмай, түүний үхэл болон Дахин амилалт.)

(15) Барнабас болон Жастины захидлуудыг онцгойлон хар

(16) Энэ бол Барнабасын захидлуудыг зохиогчийн үзэл баримтлал

(17) Энэ бол Жастины гаргасан нийтлэг үзэл баримтлал

(18) Энэ бол Барнабасын үзэл баримтлал (Хуучин гэрээ бол Еврейн алдаа)-аас татгалзахыг хэлж байгаа бөгөөд Марсион, Гностисизм (Хуучин гэрээний хамтаар Хуучин гэрээ гэж нэрлэгддэг бүтээл нь өөр Эзэн тэнгэрийн бүтээл)-г ч оруулна. Хэдий тийм ч хатуу дэгтэй еврей Христэд итгэгчид (Шинэ гэрээнд үндсэндээ шинэ юм юу ч байхгүй, харин

Хуучин гэрээг дуусгах гэсэн үргэлжлэл юм) гэж үздэг.

Бас De Baptismд 17, Энэ нь мэдээж сүмийн тогтолцоо нь Тэртулианы санааг авсан ба Acta Pauli-н чин сэтгэлийн бичгийг хүлээн авахыг хэт яаруу цуцалсан тухай юм. Августин ний нуугуй ярихдаа... Энэ нь мэдээллийн үнэтэй хэсэг юм. Гайхалтай нь Шинэ гэрээг хөрвүүлсэн номлогчид эсвэл номлогч Жон нь дундад зууны үед гарч ирэх ба энэ нь тийм ч чухал биш юм.

Бид үйл явдлыг дараах байдлаар төсөөлж болно. Эхний үе-урам зориг, бүх Христийн сүнслэг нөлөө гэж тоологддог. Цаг хугацааны явцад Христийн бичвэр нэмэгдэж агуулга нь олон янз болсноор үнэ цэнэтэй хүндэтгэл нь илүү сул, бүрхэг болж байгаа юм. Харин одоо Католик номлогчдын жишгээр шинэ үнэлгээ дүгнэлт аажмаар сүмд давамгайлж байна. Гэхдээ Католик номлогчид Эзэн тэнгэрийн шашинд хамаарна гэсэн үг биш юм. Энэхүү өөрчлөлтийн нэгэн шинж тэмдэг нь сүнснээс сүнсэнд дамжих бичвэр ба урам зориг юм. Дээр үед бүх номлогчид эрх мэдэлтэй байсан ба хэн ч үүнийг шүүмжилж чаддаггүй байв.

Бичвэрийн талаар тодорхой гол санааг нууцаар зааж сургах замаар мөн сүүлийн сургамжийн талаар номыг харж, сүмд Библи унших гэх мэтээр олон нийтийн ойлголтын цаана зөвхөн түүхэн шалтгаан бус сургамжит шашны мэдлэг байдаг гэдгийг баталсан юм

Энэхүү бодит сүсэг бишрэл нь Шинэ гэрээ бий болоход тодорхой үүрэг оролцоотой байсан 13дугаар Паулын

илгээсэн бичвэрийг бүтээл болгохын тулд нарийн нягт судалгаа хийсэн ч үр дүн багатай байв. Хэд хэдэн захидал бичгийн эмхтгэлийг боловсруулсны дараа үүнийг Ромд сүмийн өмч хэмээн зарлажээ. 20-30 жилийн дараа ч энэхүү эмхтгэл нь бие биенээсээ хол зайтай хэд хэдэн сүмүүдэд оршисоор байна. Энэ нь бидний зорилгод хангалттай юм.

Passio Perpetuea нь эхлэл бүлэгтээ үгийн гол санаа болоод дотоод харилцааг гайхалтай гаргадаг ба энэ нь бидний сонирхлыг дахин төрүүлэх болов. Цаашид олон нийтийн унших сонголт эрх нь чөлөөтэй болсон ажээ.

Марсион нь Атейзмийг өөрийн заавал биелүүлэх ёстой ажилдаа нэмсэн ба Хуучин гэрээ болон Госпэлийн санал зөрчилдөөнийг харуулсан нь сонирхолтой юм. Энэ төрлийн бүтээл нь ямар ч сэтгэгдэл төрүүлдэггүй ба бид зөвхөн энэ хэсгийг л судалдаг нь харамсалтай. Үнэндээ тэдний харах өнцөг нь энэнээс илүү муу ном бүтээл байдаг гэж төсөөлж чадахгүй байгаад юм. Энэ талаараа бид ямар ч эргэлзээгүйгээр Шинэ гэрээний байр суурийг хүлээн зөвшөөрөх ёстой юм

Католик номлогчийн бүтээл нь дайралтаас илүү хамгаалалт гэсэн утгаар зохиогдсон. Хэрэв бүтээлийн зорилго нь Гностикийн эсрэг биш бол католик номлогчийн үзэгдэл илүү хурц байх байсан бөгөөд номлогчийн дүрийн бичвэр үүнд нэмэгдсэн ба Паулиний захидлууд хавсралт маягаар нэмэгдсэн.

Хамгийн эхэнд хүч чадалтай эрх мэдэлтэй хүмүүс л хэрэглэдгийг ялгаж салгадаг байсан нь тэд нарт энэхүү номын

хүчийг ашиглах санаачлага төрүүлсэн. Үүнийг хийх үед тэр бүх ариун ном Апостолик болон Католик хэмээх бүлэг хүмүүст дийлэнх эрх нь байжээ. Тэд Христийн шашинг маш бат бөх болгон өргөжүүлсэн ба Апостолик гэдэг яг юу вэ? 12 илчийг зөвхөн илэрхийлээд байнуу эсвэл 12 өөр Хуучин гэрээний талд байна уу гэдэг эргэлзээтэй болж ирсэн. Үүнээс үүдэлтэйгээр Шинэ гэрээ гарч ирэх зам нь тавигдаж эхлэжээ.

Мөн Апостолик болон Католик 2-ын хооронд үнэхээр зөвхөн тэрхүү номыг дагах уу эсвэл шинээр эхлэх үү гэсэн бодол төрсөн бөгөөд хүмүүсийн сонголтоор тэд 2 хуваагдаж эхэлсэн. Энэ сонголтын дагуу Шинэ гэрээг эхлэх явц нь бататгагдсан ба шашин судлаач нарыг улам бүр хагаралдуулсан юм. Мөн түүнчлэн Марсион хэмээх өөрчлөн байгуулагч тэрээр Хуучин гэрээг татгалзсан хүн өөрийнхөө сүмд Луканы шашин судлаачид болон 10-н Паулиний бичсэн захидал бүхий ариун бичгүүдийг өгсөн гэдэг. Үүгээр зогсохгүй энэ нь еврейчүүдэд болон дээд сүмийн Христийн шашинтангуудад Хуучин гэрээний адил эрх бүхий байдаг гэж хэлсэн байдаг. Тэрээр Хуучин гэрээг замд нь байгаа том даваа хэмээн боддог нэгэн байсан. Гэхдээ эдгээр зүйлүүдээс хамгийн чухал нь юу вэ гэхээр Христийн шашинтангуудийн бүх ариун бичиг хүмүүст ил байдаг учир энэ нь шинийг бий болгоход мөн нөлөө үзүүлсэн гэж үздэг. Эрт цагаас эхлэн Шинэ гэрээ гарч ирсэнээр мөн шашин судлаач нарын туслалцаатайгаар Шинэ гэрээ нь Хуучин гэрээтэй эн цацуу зэрэгцэх болсон.

Мөн Христийн ариун бичигнүүд

хүмүүст ил байсныг батлах зүйлүүд бол нэг орноос нөгөө оронд шашин судлаачид болон илч нар очин амаар ярьдаг байсан түүхэн улбаатай ба Ромоос бусад газрын сүмүүдээр иш үзүүлэгч нарын Сайн мэдээг захидал хэлбэрээр түгээн хүргэж бусдад хүртээдэг байж. Хэрэв дахин өөр Сайн мэдээ ирвэл түүнийг тэр дариуд нь хэд ч байсан хамаагүй дахин дахин уншиж өгч байсан нь тэр үеийн Хуучин гэрээ буюу иргэдэд ил байдаг байсан Библи юм. Библи дээр гардаг Коринт, Ром, Филиппи, Эфэс, Хэрапелиз болон Колоссэ гэх зэрэг газруудаар дамжуулагддаг байсан ба одоо тэрхүү Библийн гэрээнүүдэд эдгээр нэр нь дурдагддаг.

/47/ Euseb., Н. Е., iv. 26, 14.

/48/ Эзэн тэнгэрийн сургаалын дагуу амьдрахаар шийдсэн нэгэнд Шинэ гэрээнд ямар нэг зүйл нэмж хасна гэдэг төсөөлөшгүй аймшигтай зүйл юм.

/49/ Монтанус нь хааны зэрэглэлд тооцогддог бөгөөд учир нь номлогчдыг дагалдагчдын дунд Баркоф болон Баркабас их нэр хүндтэй юм..

/50/ ekklesiastikai graphai сүм энэ нөхцөл байдалд өөрийн байр сууриа харуулсан юм. Гностик болон Монтанист зөрчилдөөний дунд чуулган өөрийгөө газар дэлхийд мөн диваажинд аль алинд нь харьяалагдана хэмээн үзэх болсон. Энэ бүхний өмнө сүм өөрийгөө зөвхөн диваажингийн өндөрт өргөмжлөгдсөн газар хэмээн үздэг байж.

Чуулган болон Шинэ гэрээний цуглуулбар хоорондын төстэй байдал нь мураторын хэсэгт хүчтэй санааг нэмсэн нь: буруу номын тэрсүү үзэлтнүүдийн

эсрэг тэдний урам зоригийг мохоох ном нь Шинэ гэрээ байв хэмээжээ. Ертөнцийн сүйрлийн талаарх 7 илгээлт болон Гэгээн Паулийн сүм рүү илгээсэн 7 захидал нь нэгэн сүмд дэлхий даяар түгээгээрэй хэмээн хаяглагдан иржээ.

3-р зуунд үг нь тогтвортой болж эхэлсэн. Учир нь тэрхүү захидал хамгийн чухал нь болоод байв.

2-р зуунд Сайн мэдээний бичмэлийг нилээд засварласан байдаг.

Паулийн дамжуулсан захидал маш сайн байв. Үүнээс гадна Шинэ гэрээний бичвэрийг үл харгалзан номлогчид өмнө нь тодорхой өөр өөр чиглэлийг хэр удаан баримталж байсан нь сонирхолтой юм.

4-р зууны эхэн үеэр Александрагийн Александр хуулийг бүтээгч Эзэн тэнгэр, зөнч, ба номлогчийг дуудуулжээ. Эзэн тэнгэрийн номлогчдын өвөрмөц онцлог нь сүмийн нийтийн цуглааны үеэр чимээгүй зогсохгүй байх юм, ялангуяа зүүн орнуудад мөн тусгай мөргөлийн үед ч мөн адил.

Эзэн тэнгэрийн номлогчдын (Госпэлийн) маш их тооны гар бичвэрүүд Христийн номлогчдын (Апостлын) гар бичвэрүүдтэй харьцуулагдаж өөрийгөө батлах юм. Протестантуудын хоорондох Шинэ гэрээний цуглуулбарын 2 хэсгийн хоорондох энэ өвөрмөц байдал нь Католик сүмүүдийн дунд эрчээ алдсан юм, энэ протестант үзэл нь марсионист үзлийн холбоо юм.

Зохиолын англи эх:

The Origin of the New Testament
Adolf Von Harnack, Translated by The
Rev. J.R.Wilkinson, M.A. formerly scholar
of Worcester College, Oxford and Rector
of Winford, Published by Williams and
Norgate, 1925 /Christian Classics Etherial
Library, Bringing Christian classic books
to life/ [http://www.ccel.org/ccel/harnack/
origin_nt.i.html](http://www.ccel.org/ccel/harnack/origin_nt.i.html)